



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/315

Булган сум

### Эрсдэлийн харилцаа холбооны баг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын 3.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон нийттэй харилцах эрсдэлийн харилцаа холбооны багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Эрсдэлийн харилцаа холбооны тайван цагийн болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн төлөвлөгөө, заавар, журмыг батлан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

3.Эрсдэлийн харилцаа холбооны багийн гишүүдийг чадавхжуулах, салбар хоорондын хамтын ажиллагаа, сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн оны төсөвт тусгаж ажиллахыг Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч бөгөөд Засаг даргын орлогч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010432

Аймгийн Засаг даргын 2026 оны  
ОХ дүгээр сарын 30-ны/ний өдрийн  
А/315 дугаар захирамжийн хавсралт



## ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэлийн харилцаа холбооны багийн бүрэлдэхүүн нь Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа холбооны удирдамж”-ийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Багийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч

Багийн зохицуулагч: Тухайн болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын төрлөөс хамаарч Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 4.1.2-т заасан тэргүүлэх чиглэлийн байгууллагын аймгийн түвшний байгууллагын төлөөлөл,

Багийн гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга  
Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Онцгой байдлын газрын Дэд дарга  
Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга  
Эрүүл мэндийн газрын Тархвар судлагч их эмч  
Мал эмнэлгийн газрын дарга, зооноз халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн  
Мал эмнэлгийн газрын Өвчний мэдээ, тайлан хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Сургалт, сурталчилгаа мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Тархвар судлаач  
Нэгдсэн эмнэлгийн Халдвартын их эмч  
Байгаль орчны газрын Зэрлэг ан амьтан хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

---o0o---